



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 11 өдөр

Дугаар 06

Сүхбаатар

Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага,  
дэг журмыг чангатгах зарим арга хэмжээний тухай

Дэлхийн дахинд үүсэж буй нөхцөл байдал, Монгол Улсад шинэ коронавирус бүртгэгдэн нэмэгдэж буйтай холбогдуулан халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж, Засгийн газар, улс, аймгийн Онцгой комиссоос төрийн албаны үйл ажиллагаатай холбоотой төрийн албан хаагчдын цагийн хуваарьт зохицуулалт хийх, цахим орчноос ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг олон талт арга хэмжээнүүдийг авч, холбогдох шийдвэрүүдийг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн цаг үед төрийн албан хаагчидтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн судалгааг аймгийн Цагдаагийн газраас авч, дүгнэлт хийхэд 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 11 сумын 38 байгууллагын 67 албан хаагчид гэмт хэрэг, зөрчилд холбогдсон байна.

Иймд Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн шуурхай хуралдааныг 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр хуралдуулж, үүссэн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцээд Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7, 37.1.12, 37.1.16, 37.1.17, Засгийн газрын 2018 оны "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 258 дугаар тогтоолын 1.8, 1.9, 1.10 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1."г", 3.1.2 "а", 3.1.4 "д", Улсын Онцгой комиссын 2020 оны 20 дугаар хурлын тэмдэглэл, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.3, 5 дугаар зүйлийн 5.7, Сэлэнгэ аймгийн Онцгой комиссын даргын 2020 оны 15 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга, сумдын Засаг дарга, тосгоны Захирагч, төсөвт байгууллагын удирдлагуудад дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч, хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллахыг үүрэг болгосугай. Үүнд:

1.1. Төрийн албаны манлайллыг хэрэгжүүлж, хамт олноо үлгэрлэх, төрийн албаны тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах;

1.2. Төрийн албан хаагчдыг холбогдох тогтоол, шийдвэрийн дагуу тогтсон хугацаанд цахим орчноос ажиллуулах хуваарь баталж, хэрэгжүүлэх, дотоод зохион байгуулалтын арга хэмжээг авч, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, үр дүнг тооцох;

1.3. Орон нутгийн болон байгууллагын хэмжээнд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хамгаалах, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах, амны хаалт хэрэглэхийг уриалах, шаардах, хуваарьт эргүүл ажиллуулах, хяналт тавих;

1.4. Төрийн албан хаагчдыг ажлын болон ажлын бус цагаар архи, согтууруулах ундаа хэрэглүүлэхгүй байх, байгууллагын бүртгэлтэй автомашиныг хувийн хэрэцээнд ашиглуулахгүй байх арга хэмжээг авах, зөрчил гаргасан тохиолдолд холбогдох хариуцлагыг тооцож ажиллах;

1.5. Нийтийг хамарсан аливаа арга хэмжээг зохион байгуулахгүй байх, цахим хурал, сургалтын хэлбэрт шилжих, шаардлагатай тохиолдолд халдвар хамгааллын дэглэмийг баримталж, хоорондын зохих зай барих, 10-аас дээш хүнийг нэг дор цуглуулахгүй байх;

2. Төрийн албан хаагчдад дараах арга хэмжээг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг даалгасугай.

2.1. Иргэдэд бухимдал, чирэгдэл учруулахгүйгээр соёлтой, шуурхай үйлчилж, төрийн үйлчилгээний ил тод, хариуцлагатай байдлыг хангаж ажиллах, Төрийн албаны нэр хүнд, төрийн албан хаагчийн ёс зүйг дээдлэх;

2.2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундаа хэрэглэхгүй, гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх, ёс зүйн хэм хэмжээг сахиж ажиллах;

2.3. Байгууллагаас батлагдсан ажлын цагийн зохицуулалтыг баримталж, төрийн ажил үйлчилгээг тасралтгүй явуулах, иргэдийн өргөдөл, гомдлыг тухай бүр шийдвэрлэхэд анхаарч ажиллах;


2.4. Халдвар, хамгааллын дэглэмийг сахиж, иргэд, хүүхэд залуучуудад шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой тогтоол, шийдвэрийг сурталчлан таниулах, зүй зохистой шаардлагыг тавих, зөв дадлыг хэвшүүлэхэд анхаарч ажиллах;

3. Тогтоолын хэрэгжилт, гарсан өөрчлөлт, үр дүнг заалт нэг бүрээр Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд сар бүрийн 25-ны дотор тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга, сумдын Засаг дарга, тосгоны Захирагч, төсөвт байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавих, удирдлага зохицуулалтаар хангаж, үр дүнг тооцож ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд даалгасугай.

5. Энэхүү тогтоол болон тогтоолын хэрэгжилт, үр дүнгийн талаар иргэд, олон нийтэд мэдээлэх, төрийн байгууллага, албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой санал, өргөдөл, гомдлыг 7036-3199 дугаарын утсаар хүлээн авч, тухай бүр салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн хугацаанд нь шийдвэрлүүлж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Б.Ариундэлгэр/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ө.СУВДАА